

**“Erasmus” төслийн Эко Ази дээд сургуулийн багийн
ээлжит онлайн хурлын тэмдэглэл**

2021 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

**ТХГН-ИЙН экосистемийн үйлчилгээний менежментийн чиглэлээр
магистрын сургалтын хөтөлбөр боловсруулах төслийн
АБ1 болон АБ6-ын талаар**

Хурал хийсэн газар: Хурлыг google meet ашиглан <https://meet.google.com/oud-tqib-rdt> линкээр хийлээ. Хурлыг 09:00 цагт эхэлж, 10:10 цагт дуусгав.

Хэлэлцэх асуудал:

1. АБ1 /WP1/ Судалгааны асуулгын google form-ыг эхлүүлсэн талаар
2. Төслийн хэрэгцээнд laptop болон computer урьдчилан авах талаар
3. АБ6 /WP6/ Түгээлт ба Тогтвортой байдлын үйл ажиллагаа эхэлсэн талаар

Хуралд оролцсон:

ЭКО АЗИ БОМДС-ийн Ерөнхий захирал Ц.Адъяасүрэн, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр, эрдмийн зөвлөлийн гишүүн Д.Энэбиш, ахлах багш Э.Доржпагма, экологийн тэнхмийн судлаач багш А.Төмөр-Өлзий, нягтлан Г.Сэлэнгэ, экологийн тэнхмийн Англи хэлний багш А.Гүнжээ, экологийн тэнхмийн туслах багш Н.Хэрлэнзаяа, Улаан Тайга ДЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн Б.Ичинхорлоо нар оролцов.

Хэлэлцэн шийдвэрлэсэн нь:

1. Судалгааны асуулгын google form-оо Др Зояа Ямпиллов /BSAA/-аас АБ1 /WP1/ эхэлж болно гэсэн мэйл авсан өдөр буюу 4 сарын 20-ны өдөр эхлүүлсэн. Ингэхдээ Санал асуулгын холбоосыг гишүүн бүрт хувиарлаж өгсөн **бөгөөд** зорилтот бүлгийн оролцогчдын мэйл хаяг руу илгээх болон байгаль орчны салбарын хамаарал бүхий группуудад байршуулсан. Мөн дутуу байгаа захиргааны зорилтот бүлгийн оролцогчидтой холбогдон мэйл хаяг олох ажлыг үргэлжлүүлэн хийнэ. /Ц.Адъяасүрэн Хөгнө Тарна, Дорнод Монгол, ОХБЦГ-тай холбоо барина. Д.Энэбиш Отгонтэнгэрийн Батдэлгэр, Монгол Элс-Бүрэнчөдөр нартай холбогдоно. А.Эрдэнэбаяр ОХБЦГ болон ГТБЦГ- тай тус тус холбогдож холбоос явуулах хаяг авна.
2. Laptop болон компьютерийг шалтгаанаа баримтаар нотолж авч болно гэсэн Жоржын мэйлийн дагуу бид MCS, PC Mall, Summit зэрэг газруудтай холбогдон компьютер худалдан авах нэхэмжлэл гаргуулахаар болов.
3. Др Зояа Ямпиллов /BSAA/-аас АБ6-г эхлэх талаар мэйл 4 сарын 20-д ирсэн. Үүнд төслийн мэдээллийг вэбсайтдаа байршуулж холбоосыг илгээх шаардлагатай. Бидний хувьд вэб маань асуудалтай байгаа учраас А.Эрдэнэ баяр вэб засварлах хүнтэй холбоо барихаар болов. Захианы

хариуд: “Бид вэбээ засаж байгаа учраас сургуулийн фэйсбүүк пэйж дээр төслийн мэдээллийн холбоосыг түр байрлуулсан” гэж бичихээр тохиров.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.ДОРЖПАГМА

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН :

Ц.АДЪЯАСҮРЭН